Бичсэн Ariuntugs
2019 оны 9-р сарын 06, Баасан гариг, 07:44 -

## ББСБ-ын сертификатжуулах сургалтанд урьж байна.

Монголын ББСБ-уудын холбооноос Санхvvгийн зохицуулах хороотой хамтран зохион байгуулж буй “**ББСБ-ын сертификатжуулах**” сургалт **2019.10.02-04**-ний одрvvдэд **09.00 -18.00**
цагийн хооронд Банк санхvvгийн академийн байранд зохион байгуулагдах гэж байна.

Гурван одор vргэлжлэх энэ улирлын сургалтаар харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн монгоний гvйлгээг хэрхэн мэдээлэх тухай, ББСБ-ын эрсдэлийн торлvvд тvvний удирдлага, олон улсын бичил санхvvгийн байгууллагын хогжлийн чиг хандлагын талаар хичээлийг Хороо болон Холбооны мэргэшсэн багш нар заана. Мон “Ганабелл” институтээс ББСБ-ын vйлчилгээний стандарт, харилцагчийн vйлчилгээний талаар, Монголын дотоод аудиторуудын институтээс ББСБ-ын засаглал ба vр дvнтэй дотоод хяналтын механизмыг бий болгох талаар тус тус заах юм. Тvvнчлэн сургалтын хvрээнд ББСБ-уудын удирдлагууд шvvх, шvvхийн шийдвэр гvйцэтгэл, гvйцэтгэлтэй холбогдон гарч буй хvндрэл бэрхшээл, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, шvvхийн бус журмаар шийдвэрлэх арга зам, арбитр гэж юу болох, арбитрын vйл ажиллагаандаа ашиглах боломж, компанийн тухай хууль болон компанийн засаглалын кодекс, ТУЗ-ийн ажиллах дvрэм зэрэг оргон сэдвийг хамруулан vзэх юм.

Энэхvv сургалтанд шинээр тусгай зовшоорол авсан ББСБ-ууд болон ББСБ-уудад шинээр томилогдсон удирдлагууд **ЗААВАЛ** оролцож, банк бус санхvvгийн салбарын талаар бvхий л мэдээлэл зовлогоо зэргийг авч, vйл ажиллагаандаа нэвтрvvлэх боломжтой билээ. Цаашид Банк бус санхvvгийн салбарт vйл ажиллагаа явуулж буй бvхий л ББСБ-уудын удирдлагуудыг хамруулж, сертификатжуулахыг зорьж байгаа богоод СЗХ-той хамтран сургалтанд хамрагдаж сертификат авсан хvмvvсийг нэгдсэн бvртгэлд оруулж байна.

***Бvртгэл:*** Иймд энэхvv сургалтанд оролцох хvсэлтэй ББСБ-ууд **2019.10.05-**ны дотор 8802-4181 утсаар болон nasandelger
@bbsb.mn
хаягаар бvртгvvлнэ vv. Сургалтанд бvртгvvлэхдээ оролцох ББСБ-ын нэр, ажилтаны овог, нэр, утасны дугаар, емайл хаягийг ирvvлнэ vv.

**Сургалтын төлбөр:** Холбооны гишvvн ББСБ бол нэг оролцогчийн 300.000 тогрог, гишvvн бус ББСБ бол нэг оролцогчийн 400,000 тогрог. Сургалтын толборт сургалтын гарын авлага, тараах материал, одрийн хоол, кофе брейк, сертификатны vнэ багтсан.